



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар #1189

Улаанбаатар хот

“Багануур Ус” ОНӨААТҮГ-ын данс
бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 33,158,000.0 /гучин гурван сая нэг зуун тавин найман мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Тоёото Ландкрузер маркийн 58-47 БРА улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг “Багануур Ус” ОНӨААТҮГ /М.Буддорж/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Багануур Ус” ОНӨААТҮГ /М.Буддорж/-т тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

1119282495 2576589